

ДЭЛХИЙН ДОПИНГИЙН ЭСРЭГ ДҮРЭМ

ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

ЭМЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГООР ЧӨЛӨӨЛӨХ



- Энэхүү бичвэр нь ЭМЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГООР ЧӨЛӨӨЛӨХ олон улсын стандартын 2011 оны 5.0 хувилбарын англи хэлнээс хөрвүүлсэн Монгол орчуулга болно. Англи эх болон Монгол орчуулгын хооронд зөрүү гарвал англи хэлний хувилбарыг баримтлана.
- Баримт бичгийг ЮНЕСКО-гийн санхүүжилтээр Соёл, спорт, аялал жуулчлалын яамны хэрэгжүүлсэн “Допингийн эсрэг үйл ажиллагаа” төслийн хүрээнд орчуулав.
- Орчуулсан: Н. Цогтсайхан /төслийн зөвлөх /, Хянан тохиолдуулсан: Ч.Насанбат /спортын бэлтгэлийн төвийн спортын анагаах ухааны албаны дарга/, П.Тунгалаг /МҮОХ-ны зохицуулагч/

Эмчилгээний зорилгоор чөлөөлөх олон улсын стандарт

Эмчилгээний зорилгоор чөлөөлөх олон улсын стандарт нь анх 2004 онд батлагдаж 2005 оноос эхлэн үйлчилж эхэлсэн. Эмчилгээний зорилгоор чөлөөлөх стандартын энэхүү засаж, сайжруулсан 5.0 хувилбарыг Дэлхийн Допингийн Эсрэг агентлагын гүйцэтгэх зөвлөл 2010 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр баталсан. Эмчилгээний зорилгоор чөлөөлөх олон улсын стандарт нь 2011 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс хүчин төгөлдөр болно.

Хэвлэн нийтэлсэн:

Дэлхийн Допингийн Эсрэг Агентлаг
 Stock Exchange Tower
 800 Place Victoria (Suit 1700)
 PO Box 120
 Montreal, Quebec,
 Canada H4Z 1B7

Вэб хуудас: www.wada-ama.org

Утас: +1 514 904 9232
 Факс: +1 514 904 8650
 И мэйл: info@wada-ama.org

Огноо: 2010 оны 10 дугаар сарын 1

АГУУЛГА

УДИРТГАЛ	4
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. ТАНИЛЦУУЛГА, ДҮРМИЙН ЗААЛТ БА ТОДОРХОЙЛОЛТ	5
1.0 Танилцуулга ба зорилго	5
2.0 Дүрмийн заалтууд	6
3.0 Нэр томъёо ба тодорхойлолт	8
ХОЁРДУГААР ХЭСЭГ:ЭМЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГООР ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СТАНДАРТ	12
4.0 Эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох шалгуурууд	12
5.0 Мэдээллийн нууцлал	13
6.0 Эмчилгээний зориулалтаар зөвшөөрөл олгох хороод (ЭЗЗЗОХ)	14
7.0 Олон улсын холбоо ба үндэсний допингийн эсрэг байгууллагын хариуцлага	14
8.0 ЭЗЗ хүссэн өргөдлийг хэлэлцэх ажиллагаа	16
9.0 Хэрэглээг мэдүүлэх	17
10.0 ДДЭА эмчилгээний зорилгоор чөлөөлөх шийдвэрийг хянан үзэх	17
11.0 Өмнө батлагдсан товчилсон эмчилгээний зорилгоор чөлөөлөх зөвшөөрөл (ATUEs)	18
ХАВСРАЛТ 1	19

УДИРТГАЛ

Дэлхийн допингийн эсрэг дүрмийн эмчилгээний зорилгоор чөлөөлөх (TUE) олон улсын стандарт нь дэлхийн допингийн эсрэг хөтөлбөрийн хэсэг болохын хувьд 2 дугаар түвшний эрх бүхий олон улсын стандарт болон хөгжиж байна.

Эмчилгээний зорилгоор чөлөөлөх олон улсын стандартын албан ёсны эх бичвэрийг ДДЭА хадгалах бөгөөд англи, франц хэлээр хэвлэнэ. Англи болон франц бичвэрүүдийн хооронд зөрүү гарвал англи эх хувийг баримтална.

Олон улсын TUE стандарт (5.0 хувилбар) нь 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс үйлчилж эхэлнэ.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. ТАНИЛЦУУЛГА, ДҮРМИЙН ЗААЛТ БА ТОДОРХОЙЛОЛТ

1.0 Танилцуулга ба зорилго

Эмчилгээний зорилгоор чөлөөлөх олон улсын стандартын зорилго нь спорт болон улс орнуудад эмчилгээний зорилгоор чөлөөлөх зохих баталгааг олгох үйл ажиллагааг хангахад оршино.

Дүрэм нь хориотой бодис, аргын жагсаалтанд багтаж, хэрэглэхийг хориглосон бодис аргуудыг эмчилгээний зорилгоор хэрэглэх зөвшөөрөл хүсэх зэргээр эмчилгээний зорилгоор чөлөөлүүлэх хүсэлт гаргах зөвшөөрлийг тамирчинд олгодог.

Олон улсын TUE стандарт нь эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох шалгуур, мэдээллийн нууцлал, эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох хорооны хэлбэр болон эмчилгээний зорилгоор зөвшөөрөл хүсэх журмыг агуулдаг.

Энэхүү стандарт нь дүрмэнд тодорхойлогдсон эрүүл болон хөгжлийн бэрхшээлтэй бүх тамирчдад хэрэглэгдэнэ.

Тайлбар: Энэ стандарт хувь этгээдийн шалтгааны дагуу хэрэглэгдэнэ.Тухайлбал хэрэглээг хөгжлийн бэрхшээлтэй тамирчинд зөвшөөрөх боловч бусад тамирчдад зөвшөөрөхгүй байж болно.

Дэлхийн допингийн эсрэг хөтөлбөр нь олон улсын болон үндэсний допингийн эсрэг хөтөлбөрийн тохиромжтой уялдаа холбоо болон сайн практикийг хангах бүх шаардлагатай элементүүдийг агуулдаг. Үндсэн элементүүд нь: Дүрэм(1 дүгээр түвшин), олон улсын стандартууд (2 дугаар түвшин),сайн практикийн загварууд (3 дугаар түвшин) болно.

Дүрмийн танилцуулгад олон улсын стандартуудын зорилго ба хэрэгжилтийг дараахи байдлаар нэгтгэн дүгнэсэн. Үүнд:

Допингийн эсрэг хөтөлбөрийн хүрээн дэх техникийн болон гүйцэтгэлийн хэсэгт хэрэглэгдэх олон улсын стандартуудыг Энэхүү дүрэмд гарын үсэг зурагсад болон засгийн газрууд зөвлөлдсөний үндсэн дээр боловсруулах бөгөөд түүнийг нь ДДЭА батална. Олон улсын эдгээр стандартуудыг Допингийн эсрэг хөтөлбөрийн техникийн болон гүйцэтгэлийн хэсгийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Допингийн эсрэг байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан нийцүүлэх зорилгоор боловсруулна. Олон улсын стандартуудыг Дүрэмд нийцүүлэн дагаж мөрдөх ёстой. ДДЭА-ын Гүйцэтгэх зөвлөл тодорхой асуудлаар гарын үсэг зурагсад болон засгийн газруудтай зөвлөлдсөний дараа олон улсын стандартуудыг өөрчлөх эрхтэй. Олон улсын стандартууд буюу түүнд оруулах бүх өөрчлөлт нь Энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол олон улсын стандартууд болон түүнд оруулах өөрчлөлтөд заасан мөчөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Олон улсын стандарттай (бусад стандарт, практик болон журамтай эсрэг байх,) нийцэх гэдэг нь олон улсын стандартын хүрээнд зохих хэмжээгээр хийгдсэн үйл ажиллагааг хангалттай хэмжээгээр дүгнэхэд оршино.

Дүрмэнд тодорхойлсон заалтуудыг ташуу зураасаар тэмдэглэсэн ба олон улсын TUE стандарттай заасан нэмэлт тодорхойлолтуудын доогуур зурсан болно.

2.0 Дүрмийн заалтууд

2009 оны дүрмийн дараахи бүлгүүд олон улсын TUE стандарттай шууд хамааралтай. Үүнд:

4.4 Эмчилгээний хэрэглээ

Эмчилгээний зориулалтаар эм хэрэглэх журмыг агуулсан олон улсын стандартыг ДДЭА эрхлэн гаргана.

Олон улсын уралдаан тэмцээнд оролцож буй Хориглосон бодис болон Хориглосон арга хэрэглэх шаардлагатай эмнэлгийн нөхцөл байдал бүхий олон улсын хэмжээний тамирчид буюу бусад тамирчид нь тэдгээр эм бэлдмэлийг хэрэглэх талаар хүсэлт гаргах зэрэг асуудлыг Олон улсын холбоо бүр хариуцан ажиллана.

Олон улсын холбооны Шинжилгээний Бүртгэлийн санд бүртгэгдсэн тамирчин зөвхөн холбооныхоо дүрмийн дагуу эмчилгээний зорилгоор хэрэглэх зөвшөөрөл авч болно. Олон улсын холбоо бүр эмчилгээний зорилгоор хэрэглэх зөвшөөрөл авах шаардлагатай олон улсын тэмцээний жагсаалтыг хэвлэн нийтлэнэ.

Үндэсний Допингийн эсрэг байгууллага бүр өөрийн харьяалалд байдаг Олон улсын Шинжилгээний Бүртгэлийн Санд ордоггүй тамирчдын Хориглосон бодис ба Хориглосон арга хэрэглэх шаардлагатай эмнэлгийн нөхцөл байдал бүхий олон улсын хэмжээний бус тамирчдын тэдгээр эм бэлдмэлийг хэрэглэх талаар хүсэлт гаргах зэрэг асуудлыг хариуцан ажиллана. Эдгээр хүсэлтийг Эмчилгээний зориулалтаар эм бэлдмэл хэрэглэх Олон улсын Стандартын дагуу үнэлэх болно. Олон улсын холбоод болон Допингийн эсрэг үндэсний байгууллагууд нь Үндэсний Допингийн Эсрэг байгууллагуудын Шинжилгээний Бүртгэлийн санд багтдаггүй үндэсний хэмжээний тамирчдаас бусад тохиолдолд тамирчдад эмчилгээний зориулалтаар эм бэлдмэл хэрэглэх зөвшөөрөл олгосон тухайгаа ADAMS аар дамжуулан ДДЭА-т хурдан мэдэгдэнэ.

ДДЭА өөрийн санаачлагаар тамирчдын өөрсдийн Допингийн эсрэг байгууллагын Шинжилгээний Бүртгэлийн санд багтсан олон улсын хэмжээний буюу үндэсний хэмжээний тамирчдад эмчилгээний зориулалтаар эм бэлдмэл хэрэглэх зөвшөөрөл олгосон эсэхийг шалгаж болно. Цаашилбал, эмчилгээний зориулалтаар эм бэлдмэл хэрэглэх эрхээ хасуулсан тамирчны хүсэлтийн дагуу ДДЭА тухайн хүсэлтийг хянан үзэх бөгөөд хэрэв тухайн хүсэлт нь эмчилгээний зориулалтаар эм бэлдмэл хэрэглэх тухай олон улсын стандарттай зөрчилдөж байна гэж үзвэл түүнийг хүчингүй болгоно.

Энэ заалтаар шаардсан ч Олон улсын Холбоонд тамирчинд эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох үйл ажиллагаа байхгүй бол Олон улсын түвшний тамирчин ДДЭА т дахин хянуулахаар хүсэлт гаргаж болно.

Хориотой бодис, түүний дүрс хувирал, шинж тэмдэг илрэх (2.1 заалт), Хориотой бодис эсвэл хориотой арга хэрэглэх, хэрэглэхийг оролдох(2.2 заалт), Хориотой бодис, хориотой аргыг эзэмших(2.6 заалт), Хориглосон бодис болон хориглосон аргын талаар тамирчныг удирдах буюу удирдлагын арга хэмжээ авахаар завдах (2.8 заалт)-тай холбоотойгоор Эмчилгээний зорилгоор чөлөөлөх олон улсын стандартын олгосон эмчилгээний зорилгоор чөлөөлөх хүсэлт нь допингийн эсрэг дүрэм зөрчсөнд тооцогдохгүй.

13.4 Эмчилгээний зориулалтаар хэрэглэх зөвшөөрөл олгох болон түүнийг эс олгохтой холбоотой шийдвэрийг давж заалдах

Эмчилгээний зориулалтаар эм бэлдмэл хэрэглэх эрх олгох буюу эсвэл цуцлахтай холбоотойгоор ДДЭА-гаас гаргасан шийдвэрийг гагцхүү тамирчин болон Допингийн эсрэг байгууллага зэрэг өөрсдийнх нь гаргасан шийдвэрийг өөрчилсөн этгээдүүдээс САШ-д хандан давж заалдана. ДДЭА-

аас өөрчлөөгүй бөгөөд эмчилгээний зориулалтаар эм бэлдмэл хэрэглэхийг нь үгүйгэснээс бусад Допингийн эсрэг байгууллагаас гаргасан шийдвэрүүдийг олон улсын хэмжээний тамирчдаас САШ-д, 13.2.2-д заасан хэргийн хувьд бусад тамирчдаас үндэсний хэмжээний хянан хэлэлцэх эрх бүхий этгээдүүдэд тус тус хандан давж заалдаж болно. Үндэсний хэмжээний тамирчин эмчилгээний зориулалтаар чөлөөлөх эрхийг цуцлахтай холбоотой давж заалдах гомдлоо ДДЭА-гаар дамжуулан САШ-т гаргана.

Допингийн эсрэг байгууллага эмчилгээний зорилгоор чөлөөлүүлэх хүсэлтээ тогтоосон хугацаанд ирүүлээгүйтэй холбоотойгоор ямар нэг арга хэмжээ аваагүй бол энэ нь уг заалтанд дурдсан давж заалдах эрхийг цуцлах шийдвэрийг хүртэл гаргуулахад нөлөөлнө.

14.5 Допингинд тавигдах хяналттай холбоотой мэдээллийн төв

Өөрсдийн харьяалагдах Допингийн эсрэг байгууллагын Шинжилгээний санд бүртгэлтэй олон улсын болоод үндэсний хэмжээний тамирчдын Допингийн хяналтын шинжилгээний мэдээлэл болон үр дүнг хадгалах үүргийг ДДЭА хүлээнэ. Шинжилгээ авах төлөвлөлтийг хялбарлчлах буюу Допингийн эсрэг байгууллагуудаас авах шинжилгээнд хамааруулах шаардлагагүй мэдээллүүдийг цэгцлэх үүднээс Допингийн эсрэг байгууллага бүр тэмцээний үеэр эсвэл тэмцээний дараахь шинжилгээний үр дүнг аль болох түргэн хугацаанд ДДЭА руу илгээнэ. ДДЭА нь тухайн тамирчин, түүний харьяалах үндэсний холбоо, Үндэсний олимпийн хороо, эсвэл Үндэсний Паралимпийн хороо, Допингийн эсрэг үндэсний байгууллага, Олон улсын холбоо, Олон улсын олимпийн хороо болон Олон улсын паралимпийн хороо зэрэг байгууллагуудыг дээрхи мэдээллүүдээр хангана.

Допингийн хяналтын шинжилгээнд зориулан мэдээллийн төвийг ашиглах боломжтой бөгөөд ДДЭА хувийн нууцыг хадгалах зарчимд тулгуурлан бүтээгдсэн мэдээллийн сангийн удирдлагын хэрэгсэл ADAMS-ийг хөгжүүлнэ. ДДЭА нь өөртөө болон ADAMS ашигладаг бусад байгууллагуудад ашиглахад зориулагдсан хувийн нууцтай холбоотой дүрэм журам, шалгуурыг хангасан системийг боловсруулан хөгжүүлнэ. ДДЭА нь Канад улсын нууцлалын байгууллагын удирдлага дор тамирчин, тамирчин дэмжигч этгээд, допингийн эсрэг үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдийн хувийн нууцтай холбоотой мэдээллийг хариуцах ба нууцлалыг хадгалах олон улсын стандартын дагуу чандлан нууцлана.

Үндэсний болон бүс нутгийн мэдээллийн нууцлал хариуцсан байгууллагуудтай зөвлөлдөх зорилгоор дээрхи мэдээллүүдийг дүгнэж, дор хаяж жилд нэг удаа статистик тайланг хэвлүүлэх үүргийг ДДЭА хүлээнэ.

15.4 Харилцан хүлээн зөвшөөрөх

15.4.1 13 дугаар зүйлд давж заалдах эрхийн талаар тодорхойлсны дагуу шинжилгээ, гарын үсэг зурагч этгээдээс хийж буй аливаа эмчилгээний зориулалтаар эм бэлдмэл хэрэглэх зөвшөөрөл олгох, үр дүнг хэлэлцэх, эсвэл өөрийн эрх хэмжээний хүрээнд энэхүү дүрэмд нийцүүлэн хийж буй аливаа эцсийн ажиллагааг бусад гарын үсэг зурагч этгээдүүд хүлээн зөвшөөрнө.

15.4.1-ийн тайлбар: Эмчилгээний зорилгоор чөлөөлөхтэй холбоотой энэ бүлгийн тайлбарыг андуурах тохиолдол гарсан. Олон улсын холбооны дүрэмд өөрөөр заагаагүй, эсвэл Олон улсын холбоо болон үндэсний допингийн эсрэг байгуулагатай байгуулсан гэрээний дагуу Допингийн эсрэг байгууллага олон улсын зэрэглэлийн тамирчин эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгаа өгөх эрхгүй.

15.4.2 Гарын үсэг зурагч этгээдүүд, энэхүү дүрмээр зохицуулаагүй ч гэсэн бусад байгууллагуудаас батлан гаргасан журмууд нь энэхүү дүрэмд өөр бусад байдлаар нийцсэн тохиолдолд тэдгээрийг хүлээн зөвшөөрнө.

15.4.2-ийн тайлбар: Дүрмийг хүлээн зөвшөөрөөгүй байгууллагын шийдвэрийн зарим хэсэг нь дүрэмтэй нийцсэн, зарим нь нийцээгүй тохиолдолд гарын үсэг зурагчид нь уг шийдвэрийг дүрмийн зарчимд нийцүүлэхийг хичээнэ. Жишээ нь: Жишээ нь дүрмийг хүлээн зөвшөөрөөгүй байгууллага тамирчны бие хориотой бодис илэрсэнтэй холбоотой допингийн эсрэг дүрмийн зөрчил илрүүлсэн ч шийтгэлийн хугацааг дүрэмд зааснаар богино байхаар шийдсэн бол бүх гарын үсэг зурагчид допингийн эсрэг дүрмийн зөрчил илэрснийг хүлээн зөвшөөрөх ба допингийн эсрэг байгууллага хянан хэлэлцэх үйл ажиллагааг 8 дугаар бүлгийн дагуу зохион байгуулж, дүрмийн дагуу шийтгэлийн хугацааг уртсгах эсэхийг тогтооно.

3.0 Нэр томъёо ба тодорхойлолт

3.1 Дүрэмд тодорхойлсон нэр томъёо

ADAMS: Допингийн эсрэг захиргаа, удирдлагын систем нь мэдээлэл, оруулах, хадгалах, түгээх, тайлагнахад нууц хадгалах хуулийн дагуу допингийн эсрэг үйл ажиллагаа явуулах хүрээнд оролцогч бүлгүүд, ДДЭА-т туслах зорилго бүхий вэбэд суурилсан мэдээллийн сангийн удирдлагын хэрэгсэл

Сөрөг аналитик илэрц: Лаборатори ДДЭА-аас зөвшөөрөл олгосон бусад эрх бүхий байгууллагаас олон улсын лабораторийн стандарт болон бусад техникийн бичиг баримтын дагуу гаргасан дээжинд хориотой бодис, түүний дүрс хувирал шинж тэмдэг (бие үүсдэг бодисын зохих хэмжээ хэтэрсэн нь хамаарна) илэрсэн тухай тайлан эсвэл допинг хэрэглэсэн тухай нотолгоо

Допингийн эсрэг байгууллага: Допингийн хяналтын ажиллагааны аль ч хэсгийг хэрэгжүүлэх буюу түүнд холбогдох журмыг санаачлах, хэрэгжилтийг нь хангах үүрэг хүлээсэн Гарын үсэг зурагч этгээд. Эдгээрт, Олон улсын олимпийн хороо, Олон улсын паралимпийн хороо, том тэмцээн зохион байгуулдаг бусад байгууллагууд, ДДЭА, Олон улсын холбоод болон Үндэсний допингийн эсрэг байгууллага зэрэг багтана.

Тамирчин: Допингийн хяналтын зорилгоор олон улсын (Олон улсын холбооноос тогтоосны дагуу) болон үндэсний (үндэсний допингийн эсрэг байгууллагаас тогтоосны дагуу Шинжилгээний бүртгэлийн сангаар хязгаарлагдахгүй.) хэмжээний уралдаан тэмцээнүүдэд оролцох этгээдүүд, түүнчлэн хэрэв тухайн этгээдийн үндэсний Допингийн эсрэг байгууллагаас тогтоосон тохиолдолд нэмэлт уралдаан тэмцээнд оролцож буй аливаа этгээд. Допингийн эсрэг мэдээлэл, боловсролын зорилгоор Гарын үсэг зурагч этгээд, засгийн газрууд болон энэхүү дүрмийг хүлээн зөвшөөрсөн бусад байгууллагуудаас эрх олгосны дагуу аливаа уралдаан тэмцээнд оролцож буй этгээд.

Шинжилгээ авах, эмчилгээний зорилгоор чөлөөлөх зэрэг дүрмийн бүх заалтууд олон улсын болон үндэсний хэмжээний бүх өрсөлдөгчдөд үйлчилнэ. Зарим допингийн эсрэг байгууллага баяр цэнгэлийн шинжтэй төрөл болон ахмадын ангилалын тамирчид зэрэг одоогийн байдлаар идэвхитэй биш, эсвэл үндэсний спортын төрөлд өрсөлдөгчдийг шинжилгээ авахаар сонгох, допингийн эсрэг дүрэм хэрэглэх тохиолдол байдаг Үндэсний Допингийн эсрэг байгууллага нь тийм хүмүүст дүрмийн бүх заалтыг хэрэглэх шаардлагагүй. Дүрэмтэй зөрчилдөхгүйгээр допингийн хяналтын зорилгоор олон улсын ба үндэсний зэрэглэлийн бус өрсөлдөгчдөд зориулсан үндэсний тусгай дүрмийг баталж болно. Ийм тохиолдолд баяр цэнгэлийн шинжтэй спортын тамирчидаас шинжилгээ авч болно. Харин эмчилгээний зорилгоор чөлөөлөх эсвэл байршлын тухай мэдээлэл шаардахгүй. Яг ижил нөхцөлд том тэмцээний зохион байгуулах байгууллага

зөвхөн ахмадын ангилалд өрсөлдөгчдөөс шинжилгээ авч болох авч харин эмчилгээний зорилгоор чөлөөлөх эсвэл байршлын тухай мэдээлэл авах шаардлагагүй. 2.8 (Удирдах, удирдахыг оролдох) заалтын зорилгоор ба допингийн эсрэг мэдээлэл, боловсролын зорилгоор дүрмийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурагч этгээд , засгийн газар, бусад спортын байгууллагын ивээл дор оролцогч этгээд

Тамирчны тайлбар: Энэхүү тодорхойлолтын дагуу олон улсын болон үндэсний хэмжээний бүх тамирчид, түүнчлэн Олон улсын холбоод болон Допингийн эсрэг үндэсний байгууллагуудаас зохион байгуулж буй олон улсын болон үндэсний хэмжээний тэмцээн уралдаан болгоныг энэхүү дүрмийн дагуу Допингийн эсрэг журмын зөрчлийн хяналтад хамруулна. Үндэсний хэмжээнд, энэхүү дүрэмд нийцүүлэн гаргасан журам нь дор хаяж үндэсний шигшээ багийн бүх тамирчид болон үндэсний чанартай уралдаан тэмцээнд оролцох болзол хангасан бүх этгээдэд хэрэглэгдэнэ. Энэ нь тухайн тамирчин заавал үндэсний шинжилгээний бүртгэлийн санд хамрагдах ёстой гэсэн үг биш. Үндэсний Хэрэв Допингийн эсрэг байгууллагаас зөвшөөрсөн тохиолдолд үндэсний хэмжээний тамирчдад хамаарах Допингийн хяналтын хөтөлбөрийг аливаа уралдаан тэмцээнд бага зэрэглэлийн түвшинд оролцох тамирчдад хамааруулахаар өргөтгөж болно. Аливаа уралдаан тэмцээний бүх шатанд оролцож буй тамирчдад Допингийн эсрэг зөрчлийн талаархи мэдээлэл, боловсролыг олгоно.

Дүрэм: Дэлхийн Допингийн эсрэг дүрэм

Тэмцээн: Аливаа уралдаан, тэмцээн, багийн болон түүнчлэн тамирчны ганцаарчилсан тэмцээн. Тухайлбал, сагсан бөмбөгийн тэмцээн, олимпийн хөнгөн атлетикийн гүйлтийн 100 метрийн зайн шигшээ тэмцээн, гэх мэт. Шагнал нь ердийн болон бусад түр хугацааны үндсэн дээр олгогддог урьдчилсан уралдаан болон хөнгөн атлетикийн уралдаан болон тэмцээнүүдийн хоорондын зөрүүг Олон улсын холбооноос баталсан журмаар зохицуулна.

Допингийн хяналт: Шинжилгээ авах ажлыг төлөвлөх, дээж авах болон зохицуулах, лабораторийн шинжилгээ, зохицуулалтын журам, хянан хэлэлцэх ажиллагаа явуулах болон давж заалдах зэрэг процесс энд хамаарна.

Үйл явц/арга хэмжээ: Эрх бүхий байгууллагаас зохион байгуулж буй цуврал тэмцээн (Олимпийн наадам, Олон улсын усан спортын холбооны дэлхийн аварга шалгаруулах тэмцээн болон Пан Америкийн наадам гэх мэт)

Үйл явц/арга хэмжээний хугацаа: Тэмцээн зохион байгуулагчдаас тогтоосон тэмцээн эхлэхээс дуусах хоорон дахь хугацаа

Тэмцээний үеийн: Олон улсын холбоо болон Допингийн эсрэг байгууллагаас баталсан журмуудад өөрөөр заагаагүй бол тэмцээний үеийн шинжилгээ гэдэг нь тухайн тамирчны оролцох хуваарьтай тэмцээн эхлэхээс арван хоёр цагийн өмнөөс уг тэмцээн дуусах хүртэл тухайн тэмцээнд хамааралтай дээж цуглуулах

Олон улсын тэмцээн/үйл ажиллагаа: Олон улсын олимпийн хороо, Олон улсын паралимпийн хороо, Олон улсын холбоо, Томоохон арга хэмжээ зохион явуулдаг буса байгууллагууд болон бусад олон улсын спортын байгууллагуудаас зохион байгуулж буй үйл ажиллагаа буюу тухайн үйл ажиллагааны техникийн ажилтнуудыг томилох

Олон улсын зэрэглэлийн тамирчин: Олон улсын хэд хэдэн холбоодоос тодорхойлогдсон бөгөөд Олон улсын холбооны Шинжилгээний Бүртгэлийн санд багтсан тамирчин.

Олон улсын стандарт: Дүрэмд дэмжлэг үзүүлэх зорилгоор ДДЭА-аас баталсан стандарт. Олон улсын стандартад (бусад стандарт, практик болон журамд харшилсан байх) нийцүүлсэн журмууд нь зүй зохистойгоор мөрдөгдөж байхаар байгууллагуудын үйл ажиллагаа нь Олон улсын стандартад нийцсэн байна. Олон улсын стандарт нь түүнийг мөрдөхөд шаардлагатай бичиг баримтыг агуулна.

Үндэсний Допингийн эсрэг байгууллага: Үндэсний бүхий л хэмжээнд Допингийн эсрэг журам батлах, хэрэгжилтийг нь хангах, дээж авах, шинжилгээний үр дүнгийн зохицуулалт хийх, хянан хэлэлцэх ажиллагаа явуулах бүрэн эрх олгогдож, үүрэг хүлээсэн этгээд. Хэрэв энэхүү бүрэн эрхийг олон нийтийн эрх бүхий байгууллагаас олгоогүй тохиолдолд дээрхи үүргийг тухайн улсын Үндэсний олимпийн хороо болон түүнээс эрх олгосон байгууллага хийж гүйцэтгэнэ.

Үндэсний үйл ажиллагаа/арга хэмжээ: Олон улсын болон үндэсний тамирчдыг оролцуулсан Олон улсын бус спортын арга хэмжээ.

Тэмцээний бус үеийн: Тэмцээний үеийн бус Допингийн хяналт.

Эзэмшил: Жинхэнэ бөгөөд бодит эзэмшил, эсвэл үр дүнтэй эзэмшил (Хэрэв тухайн этгээд Хориглосон бодис болон хориглосон арга, түүнчлэн хориглосон бодис болон хориглосон аргын угтвар нөхцөлд хяналт тавих туйлын эрхтэй бол) гэсэн хэдий ч тухайн этгээд хориглосон бодис болон хориглосон арга, түүнчлэн хориглосон бодис/хориглосон аргын угтвар нөхцөлд хяналт тавих туйлын эрхгүй нөхцөлд, хэрэв тухайн этгээд хориглосон бодис ба хориглосон аргын талаар мэдээж байсан бөгөөд тэдгээрийг хянахаар зэхэж байсан бол үр дүнтэй эзэмшлийн асуудал энд хамаарна. Тухайн этгээд Допингийн эсрэг журам зөрчсөн тухай ямар нэгэн мэдэгдэл авах, тухайн этгээд ямар нэгэн зүйлийг эзэмших санаанаасаа больсныгоо тодорхой үйлдлээр харуулсан буюу эсвэл эзэмшилтэй холбоотой өөрийн өмнөх асуудлыг мэдэгдсэн зэргээс өмнөх тохиолдлуудад тус тус эзэмшилтэй холбоотой ямар нэгэн Допингийн эсрэг зөрчлийн асуудал яригдахгүй.

Эзэмшлийн тайлбар: Энэхүү тодорхойлолтын дагуу тамирчны машинаас нь бодис илэрсэн бөгөөд түүний машин нь бусдын эзэмшилд байсан гэдгийг нотолсон тохиолдолд тамирчныг Допингийн эсрэг зөрчлөөс чөлөөлөх бөгөөд хэдийгээр уг машин тамирчны бүрэн хяналтан дор байгаагүй ч гэсэн тамирчин бодисын талаар мэдсэн хийгээд түүнийг бүрэн хяналтандаа оруулахыг зорьсон гэдгийг Допингийн эсрэг байгууллага нь нотлох ёстой. Үүнтэй нэгэн адилаар, хэрэв бодис тухайн тамирчны гэрийн эмийн сангаас олдсон буюу тэр нь тамирчин болон түүний ханийн хамтын хяналт дор байсан тохиолдолд тухайн бодисыг эмийн санд нь байгаа гэдгийг тамирчин мэдэж байсан бөгөөд түүнийг хяналтан дороо авахыг зорьж байсан гэдгийг мөн Допингийн эсрэг байгууллага тогтооно.

Хориглосон жагсаалт: Хориглосон бодис болон хориглосон аргыг тус тус тодорхойлсон жагсаалт.

Хориглосон арга: Хориглосон жагсаалт дээр тодорхойлсон арга

Хориглосон бодис: Хориглосон жагсаалт дээр тодорхойлсон бодис

Шинжилгээний бүртгэлийн сан: Олон улсын холбоо буюу байгууллагын шинжилгээ авах төлөвлөгөөний дагуу тэмцээний үеийн болон тэмцээний дараахь үеийн шинжилгээнд хамрагдах Олон улсын холбоо, эсвэл Допингийн эсрэг үндэсний байгууллага тус бүрээс байгуулсан дээд хэмжээний тамирчдын бүртгэлийн сан.

Гарын үсэг зурагч этгээд: Олон улсын олимпийн хороо, Олон улсын холбоод, Олон улсын паралимпийн хороо, Үндэсний олимпийн хороо, Үндэсний паралимпийн хороо, томоохон арга хэмжээ зохион байгуулагч байгууллага, Допингийн эсрэг үндэсний холбоо болон ДДЭА зэрэг энэхүү дүрмийг дагаж мөрдөхөө гарын үсэг зурах замаар илэрхийлсэн байгууллагууд.

Шинжилгээ: Шинжилгээ авалтыг төлөвлөх, дээд цуглуулах, дээж гардах болон тэдгээрийг лаборатори руу тээвэрлэх зэрэг Допингийн хяналтын ажиллагааны тодорхой хэсэг.

Хэрэглэх: Хориглосон бодис болон хориглосон аргыг ямар нэгэн замаар хэрэглэх, залгих, тариулах, эсвэл хангах бэлтгүүлэх үйл ажиллагаа.

ДДЭА: Дэлхийн Допингийн эсрэг байгууллага

3.2 Олон улсын TUE стандартад тодорхойлсон нэр томъёо

Хувийн мэдээлэл: Хувийн амьдрал ба хувь хүний мэдээллийг хамгаалах олон улсын стандартад тодорхойлсон хувийн мэдрэмтгий мэдээллээр хязгаарлагдахгүй тодорхойлогдсон ба тодорхойлогдох боломжтой оролцогчид хамаарах эсвэл бусад этгээдийн Допингийн эсрэг байгууллагуудын допингийн эсрэг үйл ажиллагааны нөхцөл байдалд дангаар боловсруулагдсан зэргийг багтаасан мэдээлэл

3.2 тайлбар: Хувийн мэдээлэлд тамирчны холбоо барих хаяг, спортын гишүүнчлэл, байршлын мэдээлэл, тодорхойлогдсон эмчилгээний зорилготой зөвшөөрөл (хэрэв байвал), допингийн эсрэг шинжилгээний дүн, үр дүнгийн зохицуулалтыг (хянан хэлэлцэх, давж заалдах, болон шийтгэл багтана.) багтааж ойлгоно. Хувийн мэдээлэл нь мөн хувийн дэлгэрэнгүй мэдээлэл, ба допингийн эмнэлгийн ажилтан болон допингийн эсрэг үйл ажиллагааны нөхцөлд түүнтэй хамт ажилладаг, эмчилгээ хийдэг, эсвэл тамирчинд тусалдаг зэрэг бусад этгээдийн холбоо барих хаягийг багтаана.

Эмчилгээний: Эдгээхэд туслах эмчилгээний хэрэгсэл болон арга зэрэг эмнэлгийн нөхцөл дэхь эмчилгээтэй хамаарах зүйл

ЭЗЧ: Дүрмээр хориглосон бодис, аргыг хэрэглэхийн өмнө авсан эмнэлгийн бичиг баримтад үндэслэн эмчилгээний зорилгоор чөлөөлөх хорооноос баталсан эмчилгээний зорилготой зөвшөөрөл

ЭЗЧХ: Эмчилгээний зорилгоор чөлөөлөх хороо нь харьяалах допингийн эсрэг байгууллагаас байгуулсан нэгж

:ДДЭА ЭЗЧХ: ДДЭА-гийн эмчилгээний зорилгоор чөлөөлөх хороо нь ДДЭА-гийн байгуулсан нэгж

ХОЁРДУГААР ХЭСЭГ:ЭМЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГООР ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СТАНДАРТ

4.0 Эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох шалгуурууд

Тамирчинд эмчилгээний зорилгоор Хориглосон жагсаалтанд орсон хориглосон бодис, эсвэл, хориглосон арга ашиглахыг зөвшөөрч (ЭЗЗ) болно. ЭЗЗ хүссэн өргөдлийг эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох хороо (ЭЗЗОХ) хянаж үзнэ. Допингийн эсрэг байгууллага нь ЭЗЗОХ-г сонгоно. Эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох хороог допингийн эсрэг байгууллага томилно.

4.1 Зөвшөөрлийг зөвхөн дараахи шаардлагад хатуу нийцүүлэн олгож болно.

a. Тамирчин хурц эсвэл архаг өвчнийг эмчлэхэд хориотой бодис эсвэл арга хэрэглэхийг хориглох нь эрүүл мэндэд ноцтой хохирол үзүүлэх талаар туршлагатай байх

b. Хориотой бодис, аргын эмчилгээний зорилготой хэрэглээ нь хууль ёсны дагуу өвчнийг эмчилж бие, эрүүл мэндийг буцаан хэвийн байдалд оруулахаас илүү ур чадварыг дээшлүүлэх нэмэгдэл үйлчилгээ үзүүлэхгүй ёсгүй. Аливаа хэвийн түвшнээс доогуур эндогений гормоны түвшинг өсгөхийн тулд хориглосон бодис, эсвэл хориглосон арга хэрэглэх нь хүлээн зөвшөөрөхүйц эмчилгээний арга гэж тооцогдохгүй

c. Хориглосон бодис, эсвэл хориглосон арга барилын хэрэглээтэй дүйцэхүйц төрлийн эмчилгээний боломжийг хэлбэр гэж үгүй.

d. Хориглосон бодис, эсвэл хориглосон арга барилыг хэрэглэх шаардлага нь хориглосон жагсаалтанд орсон бодисыг эмчилгээний бус зорилгоор өмнө нь бүхэлд нь буюу хэсэгчлэн хэрэглэсний үр дагавар байж чадахгүй.

4.2 ЭЗЗ-ийг дараахь тохиолдлуудад олгосон байгууллага нь цуцална.

a. Зөвшөөрөл олгосон Допингийн эсрэг байгууллагын тавьсан нөхцөл, эсвэл шаардлагыг тамирчин шууд дагаж биелүүлэхгүй байвал;

b. ЭЗЗО-ийг олгосон хугацаа дууссан;

c. Допингийн эсрэг байгууллага ЭЗЗ-ийг хураан авах болсон тухайгаа Тамирчинд мэдэгдсэн.

d. Эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгосон баталгааг цуцлах тухай ДДЭА, спортын арбитрын шүүхийн шийдвэр

[Тайлбар: ЭЗЗ бүр ЭЗЗОХ-оос шийдвэрлэсэн тодорхой хугацаатай байна. ЭЗЗ-ийн хугацаа дууссан, эсвэл түүнийг хураан авсан боловч ЭЗЗ-д хамаарах хориглосон бодис тамирчны биед байх тохиолдлууд байдаг. Энэ тохиолдлуудад сөрөг үр дүнг анхлан хянасан Допингийн эсрэг байгууллага тухайн нөхцөл байдал нь ЭЗЗ-ийн хугацаа дууссан, эсвэл түүнийг хүчингүй болгосонтой нийцэж байгаа эсэхийг хэлэлцэнэ.]

4.3. Эмчилгээний зориулалтаар зөвшөөрөл хүссэн өргөдөлд дор дурдсанаас бусад тохиолдолд нөхөн зөвшөөрөл олгохгүй:

a. Яаралтай эмчилгээ, эсвэл хурц өвчнийг эмчлэх зайлшгүй шаардлага байсан;

в. Онцгой нөхцөл байдлын улмаас Допингийн хяналтаас өмнө өргөдөл гаргагчдад мэдүүлэх, эсвэл ЭЗЗОХ-нд хэлэлцэх хангалттай хугацаа, эсвэл бололцоо байгаагүй.

[Тайлбар: ЭЗЗ-ийн өргөдлийг гаргахаас өмнө Хориглосон бодис эсвэл хориглосон аргын хэрэглээ шарадсан эрүүл мэндийн яаралтай тохиолдол, эсвэл эрүүл мэндийн хүнд нөхцөлүүд гарах тохиолдлууд байдаг боловч ховор. Үүнтэй адилаар, тэмцээний хугацаа ойртсон үед ЭЗЗ хүссэн өргөдлийг түргэвчилсэн байдлаар хэлэлцэхийг шаардсан тохиолдлууд бас ховор. ЭЗЗ олгогч Допингийн эсрэг байгууллагууд нь эдгээр тохиолдлыг хэлэлцэн шийдвэрлэхийг зөвшөөрсөн дотоодын журамтай байх ёстой.]

5.0 Мэдээллийн нууцлал

5.1 Допингийн эсрэг байгууллага, ДДЭА-ийн эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үед цуглуулсан, хадгалсан, боловсруулсан зарлан мэдээлсэн, үлдээсэн хувийн мэдээлэл нь Хувийн амьдрал ба хувь хүний мэдээллийг хангах олон улсын стандартад нийцсэн байх шаардлагатай.

5.2 Өргөдөл гаргагч нь өргөдөлд хамааралтай бүх мэдээллийг ЭЗЗОХ-ны гишүүдэд, шаардлагатай тохиолдолд бусад бие даан эмнэлгийн, эсвэл шинжлэх ухааны шинжээчдэд эсвэл ЭЗЗ-ийг хэлэлцэх, давж заалдах, болон удирдах үйл явцад оролцож буй шаардлагатай гэсэн албан хаагчдад шилжүүлэн өгч болно гэсэн бичгэн зөвшөөрлийг гаргаж өгөх үүрэгтэй.

5.2-ийн тайлбар: Допингийн эсрэг байгууллага тамирчнаас хувийн мэдээллийг нь эсвэл зөвшөөрөл авахын өмнө тамирчинтай холбогдож Хувийн амьдрал ба хувь хүний мэдээллийг хангах олон улсын стандартын 7.1 –г заасан мэдээллийг өгнө.

Хараат бус, гадны шинжээчдийн зөвлөгөө шаардлагатай бол Тамирчин болон түүнийг эмчилж буй эмчийн нэрийг нууцлан өргөдлийн бусад бүх мэдээллийг тарааж болно.

5.3 ЭЗЗОХ-ны гишүүд, хараат бус шинжээч Допингийн эсрэг байгууллагын захиргаа нь өөрсдийн үйл ажиллагаа маш нууц байдалд явуулах ба ЭЗЗОХ нь бүх гишүүн болон оролцогч ажилтнууд нууцлалын тухай гэрээнд гарын үсэг зурна. Ялангуяа тэдгээр нь дараахь мэдээллийг нууцална.

а. Тамирчныг эмчилж буй эмч (нар)-ээс болон тамирчнаас гаргаж өгсөн эрүүл мэндийн бүх мэдээлэл болон тоо баримт;

в. Өргөдлийн бүх мэдээлэл, түүний дотор ажиллагаанд оролцогч эмч (нар)-ийн нэр,

ЭЗЗОХ, эсвэл ДДЭА-гийн ЭЗЗОХ нь тамирчны нэрийн өмнөөс түүний эрүүл мэндийн талаар аливаа мэдээлэл авах эрхтэй гэж үзвэл энэ талаар тамирчин өөрийн эмчид бичгээр мэдэгдэнэ. Ийм шийдвэр гаргасан бол Тамирчин нь ЭЗЗ-ийн зөвшөөрөл, эсвэл хүчин төгөлдөр буй ЭЗЗ-ийн шинэчилсэн байдлаар хүлээн авахгүй.

5.4 Допингийн эсрэг байгууллага нь үйлчилж буй хууль, дүрэм, эрх бүхий хууль эрх зүйн журманд өөрөөр заагаагүй бол дүрмэнд заасан үүргээ биелүүлэх зорилгоор эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үеэр олж авсан хувийн мэдээллийг 8 жил, түүнээс цааш зөвхөн шаардлагатай хугацаанд хадгалах боломжоор хангана.

6.0 Эмчилгээний зориулалтаар зөвшөөрөл олгох хороод (ЭЗЗОХ)

ЭЗЗОХ-д дор дурдсан зааварчилгааны дагуу үйл ажиллагаагаа явуулж байгуулагдана.

6.1 ЭЗЗОХ-д наад зах нь Тамирчинд эмчилгээ хийх болон эмчилгээний ажлын туршлагатай, эмнэлгийн, спортын эмчилгээний болон эмийн хэрэглээний өндөр мэдлэгтэй гурван эмчтэй байна. Бие даасан шийдвэр гаргах баталгааг хангах үүднээс ЭЗЗОХ-ны гишүүдийн олонхи нь Допингийн эсрэг байгууллагын өмнө сонирхолын зөрчлийн эсвэл улс төрийн үүрэг хүлээхгүй байх ёстой. ЭЗЗОХ-ны бүх гишүүн ашиг сонирхлын зөрчлийн гэрээнд гарын үсэг зурна. Хөгжлийн бэрхшээлтэй Тамирчинтай холбогдсон өргөдлүүдийг хэлэлцэхэд наад зах нь ЭЗЗОХ-ны нэг гишүүн хөгжлийн бэрхшээлтэй тамирчдын эмчилгээний онцлог болон эмчилгээний өндөр туршлагатай байна.

6.2 ЭЗЗОХ-нд ЭЗЗ хүссэн аливаа тодорхой өргөдлийн нөхцөл байдлуудыг хэлэлцэх үедээ шаардлагатай гэж үзсэн эмнэлгийн, эсвэл шинжлэх ухааны судалгааны гадаад эх сурвалжийг ашиглах талаар хүсэлт гаргаж болно.

6.3 ДДЭА-нийн ЭЗЗОХ-г 6.1 дэх хэсэгт заасан шалгуурын дагуу бүрдүүлнэ. ДДЭА-гийн ЭЗЗОХ нь 7.1-т (b) тодорхойлсон олон улсын тэмцээн, арга хэмжээнд оролцогч олон улсын зэрэглэлийн, эсвэл дүрмийн 4.4-т заасанчлан үндэсний допингийн эсрэг байгууллагын шинжилгээний бүртгэлийн санд байгаа тамирчинд олгосон ЭЗЗ-ийн шийдвэрүүдийг өөрийн санаачилгаар хянахаар байгуулагдаж болно. Ердийн шалтгаантай нөхцөлд ДДЭА ЭЗЗОХ нь хүссэн бүх мэдээллээ авснаас 30 хоногийн дотор шийдвэрээ гаргана.

7.0 Олон улсын холбоо ба үндэсний допингийн эсрэг байгууллагын хариуцлага

7.1 Олон улсын холбоо бүр:

a. Эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох хороог 6 дугаар бүлэгт зааснаар байгуулах

b. Олон улсын холбооны дүрмэнд шаардсны дагуу эмчилгээний зорилгоор зөвшөөрөл авах хэрэгтэй олон улсын тэмцээний жагсаалтыг нийтлэх

c. Олон улсын холбооны шинжилгээний бүртгэлийн санд байгаа, эсвэл 7.1(b)-д тодорхойлсон олон улсын тэмцээнд оролцох хориглосон бодис, арга хэрэглэсэн тухай эмнэлгийн бичиг баримтандаа эмчилгээний зорилгоор хэрэглэх зөвшөөрөл хүссэн тамирчинд зориулж эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох үйл ажиллагаа явуулах. Эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох уг үйл ажиллагаа нь дүрмийн 4.4, энэхүү стандарт, хувийн амьдрал ба хувь хүний мэдээллийг хадгалах олон улсын стандартад нийцэж байх ёстой.

d. Олон улсын холбооны дүрмийн дагуу Допингийн эсрэг байгууллагаас олгосон эмчилгээний зорилгоор хэрэглэх зөвшөөрлийг хүлээн зөвшөөрөх тухай ямар нэг журам гаргах

e. Зөвшөөрөгдсөн бодис, арга, тун, хэрэглэх давтамж ба арга зам, эмчилгээний зорилгоор олгох зөвшөөрлийн хугацаа, эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгохтой холбоотой ногдсон ямар нэгэн нөхцөл байдал, түүний бүрэн баримт зэргийг багтаасан бүх эмчилгээний зорилготой зөвшөөрлийг ADAMS аар дамжуулж, ДДЭА-т яаралтай мэдэгдэнэ.

f. Эмчилгээний зорилготой зөвшөөрлийн баталгааг харьялах үндэсний допингийн эсрэг байгууллага болон үндэсний холбоонд яаралтай мэдээлнэ.

g. ДДЭА-гийн хүсэлтийн дагуу эмчилгээний зорилгоор олгохоос татгалзсан ямар нэг зөвшөөрлийн бүрэн баримтыг яаралтай илгээнэ.

7.2 Үндэсний Допингийн эсрэг байгууллага бүр

a. Эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох хороог 6 дугаар бүлэгт зааснаар байгуулах

b. Эмчилгээний зорилгоор чөлөөлөх зөвшөөрөл авах тамирчдыг хориотой бодис, хориотой арга хэрэглэхээс өмнө эрхийнхээ хүрээнд тамирчны ангилалыг тогтоож, хэвлэн нийтлэх. Эдгээр нь наанадаж, үндэсний допингийн эсрэг байгууллагын шинжилгээний бүртгэлийн санд байгаа тамирчин болон Үндэсний допингийн эсрэг байгууллагаас үндэсний хэмжээний зэрэглэлтэйгэж тодорхойлсон бүх тамирчдыг багтаана.

c. Олон улсын холбооны шинжилгээний бүртгэлийн санд байгаа, эсвэл 7.1(b)-д тодорхойлсон олон улсын тэмцээнд оролцох хориглосон бодис, арга хэрэглэсэн тухай эмнэлгийн бичиг баримтандаа эмчилгээний зорилгоор хэрэглэх зөвшөөрөл хүссэн тамирчинд зориулж эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох үйл ажиллагаа явуулах. Эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох уг үйл ажиллагаа нь дүрмийн 4.4, энэхүү стандарт, хувийн амьдрал ба хувь хүний мэдээллийг хадгалах олон улсын стандартад нийцэж байх ёстой.

7.2 b тайлбар: Олон улсын холбооны дүрмээр хүлээн зөвшөөрсөн, эсвэл Үндэсний допингийн эсрэг байгууллагад тухайн тамирчид эмчилгээний зорилгоор хэрэглэх баталгаа өгөх эрх олгосноос бусад тохиолдолд Үндэсний допингийн эсрэг байгууллага олон улсын шинжилгээний бүртгэлийн санд багтсан тамирчинд эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгаа олгохгүй.

d. Зөвшөөрөгдсөн бодис,арга, тун, хэрэглэх давтамж ба арга зам,эмчилгээний зорилгоор олгох зөвшөөрлийн хугацаа, эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгохтой холбоотой ногдсон ямар нэгэн нөхцөл байдал, түүний бүрэн баримт зэргийг багтаасан бүх эмчилгээний зорилготой зөвшөөрлийг ADAMS аар дамжуулж, ДДЭА-т яаралтай мэдэгдэнэ.

e. ДДЭА-гийн хүсэлтийн дагуу эмчилгээний зорилгоор олгохоос татгалзсан ямар нэг зөвшөөрлийн бүрэн баримтыг яаралтай илгээнэ.

f. Олон улсын холбооноос үндэсний допингийн эсрэг агентлагт олон улсын зэрэглэлийн тамирчдад эмчилгээний зорилгоор зөвшөөрөл өгөх эрх олгосон тухай дүрмийн дагуу эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгааг хамаарах үндэсний холбоо болон олон улсын холбоонд мэдээлнэ.

g. Олон улсын холбооноос олон улсын шинжилгээний бүртгэлийн санд байгаа эсвэл 7.1(b)-д заасан олон улсын тэмцээнд оролцох тамирчдад олгосон эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгааг хүлээн зөвшөөрөх

[Энэхүү 7 дугаар бүлэгт хэрэглэгдэж байгаа “хэвлэн нийтлэх” гэдэг нэр томъёо нь Допингийн эсрэг байгууллага дүрмийн дагуу үндэсний холбоо бүрт илгээсэн мэдээллийг вэб хуудсанд харагдахуйц байрлалд байршуулахаар илгээхийг хэлнэ.]

8.0 ЭЗЗ хүссэн өргөдлийг хэлэлцэх ажиллагаа

8.1 Олон улсын холбооны дүрмэнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд дараахи тамирчин өөрсдийн олон улсын холбооноос ЭЗЧЗ авна.

a. Олон улсын шинжилгээний бүртгэлийн санд байгаа ба

b. Олон улсын холбооны дүрмийн шаардлагаар ЭЗЧЗ авах шаардлагатай олон улсын тэмцээнд оролцох тамирчин

8.2 8.1 дүгээр бүлэгт заагаагүй тамирчин ЭЗЧЗ-ийг үндэсний допингийн эсрэг байгууллагаас авна.

8.1 ба 8.2 тайлбар: Олон улсын холбооны дүрмэнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд Үндэсний допингийн эсрэг байгууллагаас ЭЗЧЗ авсан тамирчин дараа нь олон улсын шинжилгээний бүртгэлийн санд багтах, эсвэл Олон улсын холбооноос ЭЗЧЗ авах шаардлагатай гэж тодорхойлсон олон улсын тэмцээнд оролцохоор эрмэлзэхэд олон улсын холбооноос ЭЗЧЗ-ийг шинээр авна.

“Олон улсын дүрмэнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд” гэсэн өгүүлбэр нь зарим олон улсын холбооны дүрмийн дагуу Үндэсний допингийн эсрэг байгууллагаас олгосон эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгааг сайн дураар хүлээн зөвшөөрөх болон олон улсын түвшинд шинээр эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгаа шаардахгүй тохиолдлыг харгалзан үзнэ гэсэн үг юм. Энэ дүрэм үйлчилж байгаа газар тамирчин үндэсний допингийн эсрэг байгууллагаас эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгаа заавал авна.

8.3 Тамирчин баталгаа хэрэгтэй болохоос 30 аас доошгүй хугацааны өмнө Эмчилгээний зорилгоор чөлөөлүүлэх хүсэлтээ илгээнэ.(тохиолдол, тэмцээн)

8.4 ЭЗЗ”ийг холбогдох бүх материалыг агуулсан, бүрэн гүйцэд бөглөсөн өргөдлийн маягтыг (I хавсралтын ЭЗЗ-ийн маягтыг үз) хүлээн авсны дараагаар хэлэлцэнэ. Өргөдлийг эрүүл мэндийн нууцыг чандлан хадгалах зарчимд тулгуурлан хэлэлцэнэ.

8.5 I хавсралтад заасан ЭЗЗ хүссэн өргөдлийн маягтыг Допингийн эсрэг байгууллагууд мэдээлэл авах нэмэлт хүсэлтийг агуулах зорилгоор нэг ч хэсэг, эсвэл зүйлийг хасахгүйгээр өөрчилж болно.

8.6 Хэдийгээр ЭЗЗ хүссэн өргөдлийн маягтыг Допингийн эсрэг байгууллагууд өөр хэл рүү орчуулж болох боловч франц эсвэл англи бичвэр нь өргөдлийн маягт дээр үлдэх ёстой.

8.7 Өргөдөлд тамирчны тэмцээний зэрэглэл, спорт, болон шаардлагатай тохиолдол, тодорхой байршил, үүргийг тусгана.

8.8 Өргөдөл нь эмчилгээний зорилгоор чөлөөлөх зөвшөөрөл авахаар гаргаад буй болон урьд гаргасан хүсэлтүүд, хүсэлтийг гаргасан байгууллага, тэдгээр байгууллагын хянан шийдвэрлэх эсвэл давж заалдсан шийдвэрийг жагсаасан байна.

8.9 Өргөдөлд өвчний дэлгэрэнгүй түүх, бүх үзлэгийн үр дүнг, лабораторийн шинжилгээнүүд болон дүрс оношилгооны шинжилгээний зургууд зэрэг өргөдөлд хамааралтай материалыг багтаана. Оношилгоо, эмчилгээ, хүчинтэй хугацаанд хамааралтай дүгнэлт ,нотолгоо нь ДДЭА-аас гаргасан “Эмчилгээний зорилгоор чөлөөлөх хороонд туслах эмнэлгийн мэдээлэл” гэсэн гарын авлагын дагуу хийгдэнэ.

8.10 Баталгаа өгөхөөс өмнө допингийн эсрэг байгууллагын ЭЗЗОХ-ны шаардсанаар нэмэлт шинжилгээ, үзлэг эсвэл шинжилгээний зураг авахуулах бол өргөдөл гаргагч, зардлыг хариуцах үүрэгтэй..

8.10 тайлбар: Зарим тохиолдолд тамирчны үндэсний холбоо зардлыг хариуцахаар сонгогддог.

8.11 Өргөдөл нь зохих журмын дагуу эрх авсан эмчийн зүгээс Тамирчны эмчилгээнд хориглосон бодис, эсвэл хориглосон арга хэрэглэх болсон шаардлага, яагаад тухайн нөхцөлд өөр арга, зөвшөөрөгдсөн эмчилгээ хэрэглэж болохгүй байгаа, эсвэл болохгүй байсан тухайг баталсан тайлбарыг агуулсан байна.

8.12 Хэрэглэхийг хориглосон бодис, эсвэл хориглосон аргын тун, хэрэглэх хугацаа, хугацаа, арга, давтамж болон хэмжээг нарийвчлан тодорхойлно. Ямар нэг өөрчлөлт гарвал өргөдлийн хүсэлтийг шинээр илгээнэ.

8.13 Энгийн нөхцөлд Допингийн эсрэг байгууллага холбогдох бүх бичиг баримтыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор ЭЗЗ олгох эсэх тухай шийдвэрийг гаргаж, тухайн шийдвэрийг Тамирчинд бичгээр хүргүүлнэ. Эмчилгээний зорилгоор чөлөөлүүлэх хүсэлт гаргасан өргөдөл нь тэмцээний өмнө боломжит цаг хугацаанд ирсэн бол эмчилгээний зорилгоор чөлөөлөх хороо нь тэмцээн эхлэхээс өмнө эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгох ажилллагааг дуусгахыг сайтар хичээнэ.

8.13 тайлбар: Хэрэв допингийн эсрэг байгууллага тамирчны өргөдлийг цаг хугацаанд шийдвэрлэж чадаагүй бол тамирчин татгалзсан хүсэлттэй адилаар ДДЭА-т хянан хэлэлцүүлэх хүсэлт гаргаж болно.

9.0 Хэрэглээг мэдүүлэх

9.1 Хориглосон жагсаалтанд орсон бодис, аргыг хэрэглэх тухай мэдүүлгийг шаардахаа больсон тул хэрэглэх тухай мэдүүлэг гаргаж материал өгөх шаардлагагүй.

10.0 ДДЭА эмчилгээний зорилгоор чөлөөлөх шийдвэрийг хянан үзэх

10.1 ДДЭА-ийн эмчилгээний зорилгоор чөлөөлөх хороо Олон улсын шинжилгээний бүртгэлийн санд байгаа, 7.1-т тодорхойлсон олон улсын тэмцээнд оролцох, эсвэл үндэсний допингийн эсрэг байгууллагын шинжилгээний бүртгэлийн санд байгаа тамирчдын эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгааг хэдийд ч хянан үзэж болно. Түүнчлэн 7.1, 7.2-т заасаны дагуу ирсэн мэдээлэл болон ДДЭА 8.10-т заасан шинжилгээ нэмэлт мэдээлэл шаардаж болно.

Хэрэв ДДЭА хянан үзэж эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгааг хүчингүй болгосон бол нь энэ нь буцаан хэрэглэгдэхгүй ба тухайн эмчилгээний зорилгоор чөлөөлөх баталгааны хугацаан дахь тамирчны үр дүн хүчингүй болохгүй бөгөөд шийдвэрийн тухай мэдэгдэл тамирчинд очсоноос хойш арван дөрөв (14) хоногоос хэтрэлтгүй үйлчилж эхлэнэ.

10.2 Олон улсын холбооны шинжилгээний бүртгэлийн санд байгаа 7.1(b)-д тодорхойлсон олон улсын тэмцээнд оролцох тамирчин эсвэл үндэсний допингийн эсрэг байгууллагын шинжилгээний бүртгэлийн санд байгаа тамирчин эмчилгээний зорилгоор зөвшөөрөл олгохоос татгалзсан тухай

ДДЭА-ийн шийдвэрийг дахин хянан шийдвэрлэлүүлэхээр татгалзсан шийдвэр гарсан өдрөөс хорин нэг хоногоос (21) хэтрэлгүйгээр бичгээр ДДЭА-т хүсэлт гаргаж болно. Хүсэлтийг хянан шийдвэрлүүлэхээр ДДЭА-т төлөх өргөдлийн хураамж болон эмчилгээний зорилгоор чөлөөлөх хүсэлттэй холбоотойгоор допингийн эсрэг байгууллагад явуулсан бүх мэдээллийн хуулбарыг ДДЭА-ийн эмчилгээний зорилгоор чөлөөлөх хороонд илгээх зэрэг зардлыг тамирчин хариуцна. ДДЭА-ийн эмчилгээний зорилгоор чөлөөлөх хороо допингийн эсрэг байгууллагын татгалзсан эмчилгээний зорилгоор чөлөөх зөвшөрөлд үндэслэн үнэлгээ хийх ба тодруулах зорилгоор 8.10 заасан шинжилгээ зэрэг нмэглт мэдээллийг шаардаж болно. ДДЭА-ийн хянан шийдвэрлэх үйл ажиллагаа дуусах хүртэл эмчилгээний зорилгоор чөлөөлөх зөвшөөрлийн хорио хүчин төгөлдөр үйлчилнэ. Хэрэв ДДЭА эмчилгээний зорилгоор чөлөөлөх тухай хоригийг цуцалбал уг эмчилгээний зорилгоор хэрэглэх зөвшөөрөл нь ДДЭА-ийн шийдвэрт заасан нөхцлийнг дагуу даруй хүчин төгөлдөр үйлчилнэ.

10.3 Допингийн эсрэг байгууллагын эмчилгээний зорилгоор чөлөөлөх шийдвэрийг батласан, хориг тавьсан тухай ДДЭА-ийн шийдвэрийг Дүрмийн 13 дугаар бүлэгт заасны дагуу спортын арбитрийн шүүх/CAS/-д давж заалдаж болно.

11.0 Өмнө батлагдсан товчилсон эмчилгээний зорилгоор чөлөөлөх зөвшөөрөл (ATUEs)

11.1 Дуусгавар болж,цуцлагдаж амжаагүй байгаа өмнө батлагдсан бүх товчилсон хэлбэрийн эмчилгээний зорилгоор чөлөөлөх зөвшөөрөл нь 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болох болно.

ЭМЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГООР ЧӨЛӨӨЛӨХ ХУУДАС

Бүх хэсгийг том үсгээр гаргацтай бөглөнө үү.

1.Тамирчны мэдээлэл

Овог: _____	Нэр: _____	
Эр <input type="checkbox"/>	Эм <input type="checkbox"/>	Төрсөн он сар өдөр: __он__ сар__ өдөр
Хаяг: _____		

Хот: _____	Улс: _____	Шуудангийн хаяг: _____
Утас: _____	И мэйл хаяг: _____	
Спорт: _____		Төрөл _____
Харьяалах спортын холбоо: _____		
Тэмцээний нэр: _____		
Хөгжлийн бэрхшээлтэй бол оношоо тодорхой бичнэ үү: _____		

2. Эмнэлгийн мэдээлэл

Клиникийн бүтэн онош: /Шаардлагатай шинжилгээний хуулбар, эмнэлэгт хэвтсэн бол өвчний түүхийн шаардагдах хуудасны хуулбарыг заавал хавсаргана./

Хориотой бодисыг өвчин эдгээх зорилгоор хэрэглэсэн бол түүнийг хэрэглэх болсон үндэслэл:

3. Эмийн мэдээлэл

Хориотой бодисын нэр:	Тун	Хэрэглэсэн зам	Давтамж
1.			
2.			
3.			

Хэрэглэсэн хугацаа ба хэлбэр Хажуугийн хүснэгтэд X тэмдэглэгээ хийнэ үү.	Ганц удаа Яаралтай тусламжийн зорилгоор Хугацаа(7 хоногоор):
--	--

Өмнө Эмчилгээний зорилгоор Чөлөөлөх өргөдөл гаргаж байсан эсэх: Тг г й
Хажуугийн нүдэнд **X** тэмдэглэгээ хийнэ үү

Тийм бол:

Ямар бодис? _____

Хэнд? _____ Хэзээ? _____

Эцсийн шийдвэр: өвшөөрсөн өвшөөрөөгүй
Хажуугийн нүдэнд **X** тэмдэглэгээ хийнэ.

4. Эмчийн баталгаа:

Би дээр дурдсан хориотой эмийн бодис нь зөвхөн энэ тамирчны өвчнийг эдгээх эмчилгээний зорилгоор хэрэглэсэнээ баталж байна.

Нэр: _____

Нарийн мэргэжил: _____

Хаяг: _____

Утас: _____

Факс: _____

И мэйл хаяг: _____

Эмчийн гарын үсэг: _____ Он сар өдөр: _____

5. Тамирчны баталгаа

Би _____ Дэлхийн Допингийн Эсрэг Агентлаг /WADA/ аас гаргасан хориотой бодис хэрэглэх зөвшөөрөл хүсэх өргөдөл гаргасанаа баталж байна. Миний эмчлүүлсэн тухай хувийн мэдээллийг Допингийн Эсрэг байгууллага болон Дэлхийн Допингийн Эсрэг дүрэмд заасан эрх бүхий хүмүүс ашиглахыг зөвшөөрнө.

Эдгээр мэдээллүүдийг зөвхөн Эмчилгээний Зорилгоор Чөлөөлөх баталгаа олгоход зориулагдсан шаардлагатай судалгаа, дүгнэлт хийхэд ашиглагдах болоыг ойлгож байна.

Хэрэв би өөрийн эрүүл мэндийн тухай дүгнэлт болон Допингийн Эсрэг байгууллагын гаргасан шийдвэрийн талаар нэмэлт мэдээлэл хүсэх бол өөрийн эмч эсвэл Допингийн эсрэг байгууллагадаа бичгээр хүсэлт гаргана.

Миний хуийн мэдээлэл дээр дурдсанаас бусад зорилгоор ашиглагдсан нь тогтоогдвол би Дэлхийн Допингийн Эсрэг Агентлаг эсвэл Спортын арбитрын шүүхэд гомдол гаргаж болно.

Тамирчны гарын үсэг: _____ Он сар өдөр: _____

Эцэг эхийн эсвэл асран хамгаалагчийн гарын үсэг: _____ Он сар өдөр: _____

(Хэрэв тамирчин хөгжлийн бэрхшээлтэй бол эцэг эх эсвэл асран хамгаалагч нь түүнийг төлөөлж гарын үсэг зурж болно.)